МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 02 сарын 15 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 2.9 дэх хэсэгт заасныг үндэслэн Жендэрийн үндэсний хорооны хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Жендэрийн үндэсний хорооны хуралдаанаас гарсан шийдвэр, үүрэг даалгаврыг үндэслэн дараах арга хэмжээг авч ажиллахыг Хорооны гишүүдэд чиглэл болгосугай.

1.1. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах чиглэлээр дараагийн шатны тусгайлсан төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг жендэрийн салбар хороо, салбар зөвлөлийн дарга, Хорооны гишүүдэд;

1.2. Боловсролын тэгш бус байдал, ялангуяа хүйсийн ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хөвгүүдийн боловсролын чанар, хүртээмжийн зөрүүний шалтгаан, нөхцөлийг судалж, бодит ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд;

1.3. Хөдөө, орон нутаг дахь малчид, малчин өрхийн гэр бүлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгайлсан бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд;

1.4. Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулга энэ оноос хэрэгжиж байгаатай холбогдуулан бүх нийтийн жендэрийн болон эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллахыг Хорооны гишүүдэд;

1.5. Төрөөс баримтлах жендэрийн бодлого, хууль тогтоомж, хөгжлийн бодлого төлөвлөлтийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэх болон жендэрийн тэгш бус байдал үүсэж буй асуудлаар Хорооны орлогч дарга болон жендэрийн үндэсний шинжээч, мэргэшсэн эрдэмтэн судлаачдын багийн төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад;

2. Тогтоолын хэрэгжилтийн мэдээллийг хагас жил тутам танилцуулж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Т.Энхбаяр/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ШТТ6991 5498449
ХОРОО
9019090214
УЛААНБААТАР ХОТ